

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ ЯВУУЛАХ БОЛОН МАЛЫН ЭМЧИД ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

(шинэчилсэн найруулга)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь малын эмчийн мэдлэг, мэргэшлийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэх, ур чадварыг эзэмшүүлэх, онолын мэдлэг, дадлагыг олгох мал эмнэлгийн төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт /цаашид “төгсөлтийн дараах сургалт” гэх/ зохион байгуулах болон малын эмчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл /цаашид “итгэмжлэл” гэх/ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх малын эмч нь итгэмжлэл авах бөгөөд төрийн албанд мэргэжлээрээ ажиллаж байгаа малын эмч хуульд өөрөөр заагаагүй бол хүсэлт гаргаж итгэмжлэл авч болно.

1.3. Төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалт зохион байгуулах, итгэмжлэл олгох, нөхөн олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх ажлыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллах орон тооны бус сургалтын комисс хариуцан гүйцэтгэнэ.

1.4. Энэ журмын 1.3.-т заасан зарим үйл ажиллагааг сонгон шалгаруулалтын үндсэн дээр салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгүүлж болно.

Хоёр. Төгсөлтийн дараах сургалт, итгэмжлэл олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

2.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар энэхүү журмын 1.3-т заасан сургалтын комиссын бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлөх ба дүрмийг батална.

2.2. Комисс нь мал эмнэлгийн төрийн болон төрийн бус байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн байгууллага болон мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдэх ба дарга, нарийн бичгийн дарга, 9-өөс доошгүй гишүүнтэй байна.

2.3. Сургалтын комиссын нарийн бичгийн дарга нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын итгэмжлэлийн сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

2.4. Сургалтын комисс нь төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалт, итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, бүртгэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх, хяналт тавих хүрээнд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ;

2.4.1. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хөтөлбөрийг мал эмнэлгийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр боловсруулах, батлуулах, хяналт тавих;

2.4.2. төгсөлтийн дараах болон итгэмжлэл, малын бага эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан, малчин, мал бүхий иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг батлах, сургалт эрхлэх байгууллага, мэргэжлийн холбоодыг сонгон шалгаруулж Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэр гаргуулж, жагсаалтыг цахим санд байршуулах, шинэчлэх;

2.4.3. төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах болон итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.4.4. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэл олгох асуудлаар баримтлах бодлого, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, багц цаг тооцох, бүртгэх, сургалтын төлбөрийн дээд хязгаарыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.4.5. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын явцад хяналт тавих, итгэмжлэлийн шалгалт зохион байгуулах удирдамж, шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Мал, амьтны эрүүл

мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар тухай бүр нь томилж, арга зүй, удирдлагаар хангах;

2.4.6. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулж, мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх;

2.4.7. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, маягт, загвар, арга, аргачлалыг боловсруулж, мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар шийдвэрлүүлэх, мөрдүүлж ажиллах;

2.4.8. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааг мэргэжлийн баг, судлаачдаар гүйцэтгүүлэх;

2.4.9. итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх шийдвэрийг үндэслэн итгэмжлэлийн гэрчилгээг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, баталгаажуулан, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагын удирдлага, сургалт, хүний нөөц, үйлчилгээний байгууллагад хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх;

2.4.10. сургалтын хөтөлбөрүүдээр шалгалтын сорилын тест боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж, цахим мэдээллийн санд байршуулах;

2.4.11. тухайн жилийн ажлын тайланг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын зөвлөлд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор танилцуулах;

2.4.12. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтад хамрагдсан малын их, бага эмч, мал эмнэлгийн техникийн ажилтны мэдээллийг мал эмнэлгийн салбарын хүний нөөцийн хөгжил, удирдлагын систем (МЭХНХУС)-д бүртгэх ба энэхүү систем нь мал эмнэлгийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдхүүн хэсэг байна.

2.4.13. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэл олгох асуудлаар холбогдох баримт бичгийг Архив, албан бичиг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэж, мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хадгалах;

Гурав. Сургалт эрхлэх байгууллага, түүний эрх үүрэг, сургалтын хэлбэр

3.1. Төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтыг мал эмнэлгийн салбарын байгууллага, мэргэжлийн холбоо хариуцан зохион байгуулах ба дараахь шаардлагыг хангасан байна:

3.1.1. улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх;

3.1.2. тухайн багц цагийн сургалтын чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

3.1.3. сургалтын танхим, техник хэрэгсэл, *дадлага сургалтын бааз*, тоног төхөөрөмжтэй, хөтөлбөрийн дагуу боловсруулсан ном сурах бичиг, гарын авлага материалтай байх;

3.1.4. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх, ур чадвартай багшлах бүрэлдэхүүн, сургагч багштай байх;

3.2. Сургалтын байгууллага, мэргэжлийн холбооны үйл ажиллагаа.

3.2.1. батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заагдсан мэдээллээр малын эмч, малын бага эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан, малчин, мал бүхий иргэдийг хангах;

3.2.2. сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө болон сорилын санд үнэлгээ хийх, сорилын сангийн 20-иос доошгүй хувийг жил бүр шинэчлэн, шалгалтын сорилын сангийн нууцлалыг хадгалах;

3.2.3. энэхүү журмын 3.3-т заасан хөтөлбөр нь нэг жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын

өмнө сургалтын эрх авсан байгууллага нь хөтөлбөрөө сунгуулах, шинэчлэх тухай хүсэлтээ мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

3.2.4. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хөтөлбөрт заасан сэдвийн дагуу сорил авч, суралцагчийн мэдлэг, ур чадварыг тогтоох;

3.2.5. сургалтын тайлан, холбогдох баримт бичгийг шалгалт дууссанаас хойш орон нутагт хийсэн бол ажлын 7 хоногийн дотор, нийслэлд ажлын 4 хоногийн дотор сургалтын комисст бичгээр болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх;

3.3. Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага:

3.3.1. сургалтын хөтөлбөр нь төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн гэсэн 2 төрөлтэй байх;

3.3.2. малын эмчийн онолын мэдлэг, ур чадвар, дадлага, *мэргэжлийн ёс зүй*, харилцаа хандлагыг тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулахад чиглэгдсэн байх;

3.3.3. тухайн хөтөлбөрт заагдсан агуулгыг багтаасан сорилын тесттэй байх;

3.4. Сургагч багшид тавигдах нийтлэг шаардлага:

3.4.1. тухайн мэргэжлээрээ магистр ба түүнээс дээш боловсролын цолтой, ахлах, тэргүүлэх, зөвлөх мэргэшлийн зэрэгтэй байх;

3.4.2. нийт сургагч багш нарын 50-иас доошгүй хувь нь тухайн мэргэжлээрээ найм ба түүнээс дээш жил ажилласан байх;

3.4.3. мэргэшлийн онцлог, тухайн багшийн эзэмшсэн тусгай ур чадвар, мэргэшлээс хамааран сургалтын багт бакалавр зэрэгтэй, шинээр сургууль төгссөн эсвэл орон нутагт мэргэжил, мэргэжлээрээ ажиллаж байгаа эмч, мэргэжилтэнг ажиллуулж болно.

3.4.4. энэхүү журмын 3.4.3-т заасан сургагч багшийн тоо нийт багшлах бүрэлдхүүний 30 хувиас хэтрэхгүй байна.

3.4.5. сургалт эрхлэх байгууллага, мэргэжлийн холбоодтой гэрээ байгуулсан байх (тухайн байгууллагын үндсэн ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ, гэрээт ажилтны хувьд сургалт хийх гэрээ байгуулах);

3.4.6 Гадаад мэргэжилтэн, тухайн чиглэлээр нарийн мэргэшсэн профессор багш сургагч багшаар ажиллаж болно

3.5. Төгсөлтийн дараах сургалт:

3.5.1. төгсөлтийн дараах сургалт нь цахим, танхим, дижитал, практик дадлага хэлбэртэй зохион байгуулагдана.

3.5.2. төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр нь сургалтын чиглэлээс хамааран онолын мэдлэгийг 70.0-80.0 хувиар, дадлага ажлыг 20.0-30.0 хувиар тооцно.

3.6. Итгэмжлэлийн сургалтын багц цаг, үр дүнг тооцох:

3.6.1. итгэмжлэлийн сургалтын хөтөлбөр нь нийт 6 багц цагаас бүрдэх ба багц цаг нь 8 цагаас багагүй хөтөлбөртэй байна.

3.6.2. нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 мин, аудио, видео хичээлийн үргэлжлэх хугацаа 30 мин-аас ихгүй байх ба итгэмжлэлийн сургалтыг зөвхөн танхимын хэлбэрээр зохион байгуулна;

3.6.3. итгэмжлэлийн сургалтын багц цагийн 2/3-оос доошгүй нь итгэмжлэлийн хүрээнд хамаарах мэргэжил, мэргэшилд хамаарах ба үлдсэн 1/3 нь ёс зүй, хууль эрх зүй, халдвар хамгаалал, нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

3.6.4. итгэмжлэлд хамрагдсанаас хойш малын эмч нь жил бүр 6-аас доошгүй багц цагийн төгсөлтийн дараахь сургалтад заавал хамрагдаж, дараагийн итгэмжлэл авах хүртэл нийт 30-аас доошгүй багц цаг цуглуулах ба сургалтын комиссын баталгаажуулсан төгсөлтийн дараах сургалтаас 90 хувийг, итгэмжлэлийн сургалтаас 10 хувийг тус тус цуглуулна.

3.6.5 Малын эмч, мэргэжилтний тухайн жилд биелүүлсэн багц цаг нь энэхүү журмын 3.6.4-д зааснаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.

3.6.6. итгэмжлэлийн сургалтад хамрагдсан малын эмчээс баталсан сорилоор шалгалт авна;

3.6.7. сорилд 75.0 хувиас дээш оноо авснаар итгэмжлэл авах шаардлагыг хангана;

3.6.8. итгэмжлэлийн сургалтад хамрагдсан боловч сорилд тэнцээгүй бол шалгалттай холбоотой гомдлыг эцэслэн шийдвэрлэхээс өмнө дахин нэг удаа шалгалт өгч болно.

Дөрөв. Итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах

4.1. Дараахь тохиолдолд малын эмчид итгэмжлэл олгоно:

4.1.1. магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг малын эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн малын эмч итгэмжлэлийн *сургалтанд сууж шалгалтанд тэнцсэнээр* итгэмжлэлийг 3 жилийн хугацаагаар олгоно;

4.1.2 магадлан итгэмжлэгдсэн коллежийг малын эмч мэргэжлээр дипломын боловсрол эзэмшиж төгссөн малын эмч нь итгэмжлэлийн сургалтад хамрагдаж төгссөнөөр итгэмжлэлийг 3 жилийн хугацаагаар олгоно.

4.1.3. бусад тохиолдолд итгэмжлэлийн хүчинтэй хугацаа 5 жил байна;

4.1.4. таван жилийн хугацаатай итгэмжлэлийг өмнө нь 4 удаа авсан малын *их* эмч, мэргэшлийн зөвлөх зэрэгтэй малын эмч нь ээлжит итгэмжлэлийн сургалтад хамрагдаж, шалгалт өгч тэнцэж, сургалтын комисст хүсэлт гаргасан тохиолдолд итгэмжлэлийг хугацаагүйгээр олгож болно;

4.1.5. энэхүү журмын 4.1.1-4.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэхдээ сургалтын комисс дүгнэлт гаргаж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр итгэмжлэл олгоно.

4.2. Итгэмжлэлийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ.

4.2.1. мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.17 дахь заалтыг зөрчсөн;

4.2.2. мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд нь өөрийн буруугаас шалтгаалан хэрэгжүүлээгүйгээс хүн ам болон эдийн засагт хохирол учруулдаг мал, амьтны өвчин гарсан;

4.2.3. эм бэлдмэлийн хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээний технологийн алдаа гаргасан, хамрагдвал зохих мал, амьтныг дутуу хамруулсан;

4.2.4. мал эмнэлгийн ажил, үйлчилгээний тайлан, бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн;

4.2.5. итгэмжлэлийг хугацаагүйгээр авсан малын эмч нь энэ журмын 3.6.4 дэх заалтын шаардлагыг хангаагүй бол;

4.2.6. энэхүү журмын 4.2.1-4.2.5-т заасан зөрчил нь мэргэжлийн байгууллагаар нотлогдсон бол Мал, амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр итгэмжлэлийг 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.

4.3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр дараах зөрчлүүд тогтоогдсон бол малын эмчийн итгэмжлэлийг Мал,

амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр цуцална.

4.3.1. мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн буруугаас хэрэгжүүлээгүй, холбогдох заавар, журмыг зөрчсөн, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдвал зохих мал, амьтныг хамруулаагүй эсхүл дутуу хамруулснаас гоц халдварт өвчин гарч улсад их хэмжээний хохирол учруулсан;

4.3.2. улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаагүй, хуурамч малын эм, бэлдмэл түгээх, худалдан борлуулах болон хэрэглэсэн;

4.3.3. энэхүү журмын 4.2.5-т заасан хугацаанд мал эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхлэхдээ гаргасан зөрчил, дутагдлаа бүрэн арилгаагүй, энэхүү журмын 4.2.1-4.2.4-т заасан зөрчлийг давтан гаргасан.

4.4. Журмын 4.2-т заасан үндэслэлээр итгэмжлэл нь түдгэлзсэн малын эмч нь шийдвэрт заасан хугацаанд холбогдох зөрчлийг арилгасан тухай нотолгоо бүхий тайланг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж дүгнэлт гаргуулна.

4.5. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын дүгнэлтийг үндэслэн тухайн асуудлаар сургалтын комисс шийдвэр гаргаж Мал, амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр итгэмжлэлийг сэргээх эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

Тав. Төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын талаар мал эмнэлгийн байгууллага, малын эмчийн эрх үүрэг

5.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэлийн талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

5.1.2. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэлийн сургалтын үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах зардлыг санхүүжүүлэх;

5.1.3. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалттай холбоотой байгууллага, эмч, мэргэжилтэн, иргэн, бусад хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;

5.1.4. сургалтын комиссын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгөх;

5.1.5. итгэмжлэлийн шалгалтын сорилыг бүрдүүлэх, шинэчлэх, сорилын сангийн нууцлалын талаар гэрээг сургалтын эрх бүхий байгууллага, мэргэжлийн холбоотой байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

5.1.6. Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох;

5.1.7. Итгэмжлэлийн гэрчилгээний үнэ тогтоох;

5.1.8. Сургалтын комиссын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгөх;

5.2. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. итгэмжлэлд хамаарах малын эмчийн судалгааг шинэчилж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

5.2.2. итгэмжлэлийн сургалтад хамрагдах шаардлага хангасан нь малын эмчийн хүсэлтийг сургалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

5.2.3. батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын хуваарь, бусад холбогдох мэдээллийг малын эмч нарт хүргэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд санал өгөх;

5.2.4. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хугацаанд малын эмч, мэргэжилтэн нарын ажлын зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх;

5.2.5. итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх асуудлаар дүгнэлт гаргаж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

5.2.6. малын эмч, мэргэжилтэний жил бүр биелүүлэх багц цагийн бүрдүүлэлтэд тогтмол хяналт тавьж, тухайн жилд багц цаг нь бүрдүүлээгүй эмч, мэргэжилтэнд мэдэгдэл хүргүүлэх;

5.2.7. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хэрэгцээ, шаардлага тодорхойлох судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх;

5.3. Мал эмнэлгийн тасаг нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын асуудлаарх судалгааг жил бүр шинэчлэх;

5.3.2. итгэмжлэлд хамрагдах хүсэлтийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт 30-аас доошгүй хоногийн өмнө уламжлах, баримт бичгийн бүрдэл хангуулах;

5.3.3. батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтад хамрагдах малын эмч нарт мэдээлэл хүргэх;

5.3.4. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хугацаанд малын эмч нарын ажлын зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх;

5.3.5. итгэмжлэл бүхий малын эмчийн асуудлаар холбогдох дүгнэлт гаргаж, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэх;

5.3.6. төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтын хэрэгцээ, шаардлага тодорхойлох судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд санал өгөх;

5.4. Малын эмч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.4.1. итгэмжлэлийн хугацаа дуусахаас хуанлийн 90-ээс доошгүй хоногийн өмнө итгэмжлэлийн сургалтад хамрагдах хүсэлтийг мал эмнэлгийн тасагт гаргах;

5.4.2. төрийн албанд мэргэжлээр ажиллаж байгаа малын эмч нь байгууллагаараа дамжуулан итгэмжлэлийн сургалтад хамрагдах хүсэлт гаргах;

5.4.4. мэргэшлийн тэргүүлэх зэрэгтэй малын эмч нь итгэмжлэлийн сургалтад хамрагдах шаардлагын 50 хувийг хангаснаар сургалтын комисст хүсэлт гаргаж, итгэмжлэлийн сургалтад хамрагдах;

5.4.5. төгсөлтийн дараах батлагдсан багц цагийн сургалтын хөтөлбөрөөс сонгон суралцаж, жил тутам энэхүү журмын 3.6.4-т заасан багц цагийг биелүүлж, итгэмжлэлийн багц цагт тооцуулах;

5.4.6. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэлтэй холбоотой санал, хүсэлт, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, лавлагаа, тодорхойлолт гаргуулах.

5.4.7. төгсөлтийн дараах сургалт болон итгэмжлэлтэй холбоотой гарах төлбөрийг төлөх;

5.4.8. итгэмжлэл сэргээлгэх, төгсөлтийн дараах болон итгэмжлэлийн сургалтад хамрагдах хүсэлт гаргах;

5.4.9. итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дууссан болон итгэмжлээ цуцлуулсан тохиолдолд мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэхгүй байх;

Зургаа. Бүртгүүлэх баримт бичиг

6.1. Анх удаа итгэмжлэлийн сургалтад хамрагдах малын эмч дараах бичиг баримтыг бүрдүүлж, мал эмнэлгийн хүний нөөцийн цахим санд бүртгүүлнэ. Үүнд:

6.1.1 сургалтад хамрагдах хүсэлт /өргөдөл/;

6.1.2 иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл цахим лавлагаа;

6.1.3 боловсрол, мэргэжлийн үнэмлэх, диплом эх хувиар /хэрвээ гадаадад боловсрол эзэмшсэн бол баталгаат орчуулгыг нэмж хавсаргах/;

6.1.4 4x6 хэмжээний 4 хувь цээж зураг (сүүлийн 6 сард авахуулсан байх);

6.1.5 анкет /маягт №1/;

6.1.6 тухайн малын эмчийн ажиллаж байгаа эсхүл оршин суугаа орон нутгийн /мал эмнэлгийн тасаг/ төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

6.2. Итгэмжлэл сунгуулах сургалтад хамрагдахыг хүссэн малын эмч энэхүү журмын 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.1.6-аас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

6.2.1 итгэмжлэлийн гэрчилгээний хуулбар;

6.2.2 итгэмжлэлийн хүрээнд хамаарах мэргэжил, мэргэшлийн чиглэлээр хамрагдсан сургалтын багц цагийг гэрчлэх баримт бичиг.

6.3. Энэхүү журмын 4.1.4-д заасан итгэмжлэлийг авахыг хүссэн малын эмч нь журмын 6.1.1, 6.1.2, 6.1.5, 6.1.6, 6.2.1-ээс гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

6.3.1 зөвлөх зэрэг олгосон байгууллагын шийдвэрийн хуулбар;

Долоо. Сургалтын үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1. Нэн шаардлагатай сургалтыг улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр;

7.2. Сургалтын болон олон улсын байгууллага, төсөл, төслийн байгууллагын санхүүжилтээр;

7.3. Малын эмчийн өөрийн санхүүжилтээр;

7.4. Энэхүү журмын 4.1.1, 4.1.4, 5.4.4 дэх заалтын дагуу итгэмжлэл авахдаа малын эмч зөвхөн итгэмжлэлийн гэрчилгээний үнийг төлнө.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн мал эмнэлгийн салбарын байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, сургалтын болон шалгалтын комисс, малын эмч мэргэжилтэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----